



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 03 өдөр

Дугаар 11384

Арвайхээр

Г Хөрөнгө зарцуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.11 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн "Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалт батлах тухай" 90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Арвайхээр сумын шинэ суурьшлын бүсэд шинээр байгуулах Цэцэрлэгт хүрээлэнг хашаажуулах зардалд 96,080,000 (ерэн зургаан сая наян мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Цэцэрлэгт хүрээлэнг хашаажуулахад шаардагдах төмөр хайсыг дотоодын жижиг дунд үйлдвэрлэгч нараас сонгон шалгаруулж, гэрээ шууд байгуулах аргыг ашиглаж худалдан авахыг Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Ч.Гүнсэнхорол)-д даалгасугай.

3. Дээрх зардлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 09/06 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтын 1 дэх хэсэгт тусгагдсан зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ц.Идэрсайхан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ



6222 11 0487